



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/36

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 19.20, Зөвшөөрлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.5, 6 дугаар зүйлийн 6.2, дахь заалт, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлгэрхаан суманд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн “Арьсны өвчин судлалын төв”-ийн харьяа сувилал, Хэрлэн суманд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн “Туушин тал” ХХК-ийн “Оргил-2” эмийн сан, Хэрлэн суманд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн “Энхрий нандин зүрх” ХХК-ийн зүрх судасны үүдэн эмнэлэгт эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн тус тус 3 жилээр олгосугай.

2. Бор-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж буй “Ээс Бодь” ХХК-ийн эмийн сангийн мансууруулах нөлөөт эмээр үйлчлэх зөвшөөрлийг 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай шинээр олгосугай.

3. Дадал суманд үйл ажиллагаа явуулж буй “Чингисийн гурван нуур” ХХК-ийн сувиллын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн цуцалсугай.

4. Тус байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллахыг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга (Х.Доржханд), Эмийн бодлого, чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн (О.Энх-Уянга) нарт даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Д.Наранмичид)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ДАШНАМЖИЛМАА

